



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/133/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70592225

Цахим хаяг: [Oyun-erdenet@audit.gov.mn](mailto:Oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр  
Утас: 70593113

Цахим хаяг: [ikhbayard@audit.gov.mn](mailto:ikhbayard@audit.gov.mn)

Аудитор Л.Баянмөнх

Утас: 99997540

Цахим хаяг: [bayanmunkhamina@gmail.com](mailto:bayanmunkhamina@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.28 № 56

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

### ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Б.НАНЖИД ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 183.8 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилт, 53 арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг ханган ажилласнаар 94.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

4825020194

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>108,680,337.51</b>	<b>119,164,238.78</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>		
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,192,452.72	13,340,790.08
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2,192,452.72	13,340,790.08
31211	Төрийн сангийн харилцах	30,259.74	13,128,597.10
31218	Ахмадын сангийн харилцах	216,219,2.98	212,192.98
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	30,218,899.43	39,005,623.66
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	877,726.43	9,489,304.46
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	15,442,757.00	16,398,113.20
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	13,898,416.00	13,118,206.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	13,898,416.00	13,118,206.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	76,268,985.36	66,817,825.04
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	47,197,266.36	43,664,586.04
35110	Тусгай зориулалттай материал	18,441,427.38	29,346,810.67
35130	Эм боох материал	28,755,838.98	14,317,775.37
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	29,071,719.00	23,153,239.00
35410	Бичиг хэргийн материал	319,100.00	689,100.00
35420	Аж ахуйн материал	14,704,139.00	22,338,539.00
35440	Түлш, шатах тослох материал	312,860.00	125,600.00
35450	Барилгын засварын материал	13,601,100.00	0.00
35460	Хүнсний материал	134,520.00	0.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>307,224,744.04</b>	<b>559,800,955.34</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	307,224,744.04	559,800,955.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	299,182,744.04	551,812,955.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	218,132,250.38	218,132,250.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,546,792.14)	(20,980,922.18)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,485,863.00	235,385,229.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,351,756.05)	(43,645,008.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,682,973.05	198,795,935.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,857,448.65)	(50,004,964.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,158,400.00	20,254,326.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,520,745.55)	(6,123,890.78)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,042,000.00	7,988,000.00
39301	Програм хангамж	270,000.00	270,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(54,000.00)	(108,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,826,000.00	7,826,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>415,905,081.55</b>	<b>678,965,194.12</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>20,256,900.00</b>	<b>65,817,414.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	20,256,900.00	65,817,414.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	20,256,900.00	65,817,414.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	16,585,996.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	20,256,900.00	40,888,118.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.00	8,343,300.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	8,343,300.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>395,648,181.55</b>	<b>613,147,780.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	395,648,181.55	613,147,780.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	173,735,018.94	173,735,018.94
51101	Өмч: - төрийн	173,735,018.94	173,735,018.94
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	221,913,162.61	439,412,761.18
51210	Өмнөх үеийн үр дүн	254,074,632.82	221,658,258.05
51220	Тайлант үеийн үр дүн	(32,161,470.21)	217,754,503.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>415,905,081.55</b>	<b>678,965,194.12</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>430,766,548.20</b>	<b>950,937,214.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>44,138,395.68</b>	<b>295,068,870.37</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	44,138,395.68	295,068,870.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,162,000.00	4,219,770.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,162,000.00	4,219,770.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	14,206,872.20	270,982,542.99
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,769,523.48	19,866,556.88
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>386,628,152.52</b>	<b>655,868,343.82</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	27,970,800.00	36,495,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,970,800.00	36,495,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	358,657,352.52	619,372,643.82
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	358,657,352.52	619,372,643.82
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>462,928,018.41</b>	<b>729,753,420.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>462,928,018.41</b>	<b>729,753,420.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	462,927,818.41	729,655,286.61
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	244,771,490.49	428,565,868.63
210101	Үндсэн цалин	164,072,135.98	235,028,360.63
210102	Нэмэгдэл	66,805,295.68	155,757,808.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,072,999.43	7,358,000.00
210104	Урамшуулал	11,821,059.40	30,421,700.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,169,503.71	53,594,610.70
210201	Тэтгэврийн даатгал	21,881,714.25	36,932,954.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,291,529.93	4,285,256.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,107,284.48	2,142,628.16
210204	Ажилгүйдлийн даатгал	444,451.30	1,865,189.87
210205	Эрүүл мэндийн даатгал	4,444,523.75	8,368,582.01
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,138,420.00	31,607,465.75
210301	Гэрэл, цахилгаан	2,837,900.00	3,111,795.75
210302	Түлш, халаалт	26,300,520.00	28,495,670.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	36,604,600.62	27,006,715.50
210401	Бичиг хэрэг	1,686,250.00	1,653,700.00
210402	Тээвэр, шатахуун	13,823,410.00	22,476,947.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	955,000.00	687,368.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	541,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,366,500.00	1,647,700.00
210408	Бараа материал акталсны зардал	16,773,440.62	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	77,159,534.90	92,988,136.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,531,419.90	87,829,115.10
210502	Хоол, хүнс	5,628,115.00	5,159,021.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	761,000.00	36,086,600.00
210604	Урсгал засвар	761,000.00	36,086,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,747,000.00	10,905,500.00
210702	Дотоод албан томилолт	8,747,000.00	10,905,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,139,304.00	1,941,853.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	110,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,044.00	98,034.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	78,260.00	67,969.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,436,964.69	46,958,536.93

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,445,850.00	3,226,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,991,114.69	43,732,136.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	200.00	98,134.25
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	200.00	98,134.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	200.00	98,134.25
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(32,161,470.21)</b>	<b>221,183,793.33</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	3,429,290.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,429,290.20
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(3,429,290.20)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(32,161,470.21)</b>	<b>217,754,503.13</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>386,572,751.07</b>	<b>659,810,025.63</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,387,355.55</b>	<b>4,897,038.01</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15,387,355.55	4,897,038.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,387,355.55	4,897,038.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,387,355.55	4,897,038.01
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>371,185,395.52</b>	<b>654,912,987.62</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	27,970,800.00	36,495,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,970,800.00	36,495,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	343,214,595.52	618,417,287.62
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	343,214,595.52	618,417,287.62
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>397,164,081.93</b>	<b>627,994,988.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>397,164,081.93</b>	<b>627,994,988.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>397,163,881.93</b>	<b>627,896,854.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	258,566,964.09	393,742,175.60
210101	Үндсэн цалин	172,880,882.34	178,767,468.00
210102	Нэмэгдэл	75,742,867.12	155,757,808.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,004,999.43	7,358,000.00
210104	Урамшуулал	7,938,215.20	51,858,899.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,369,962.54	80,340,943.27
210201	Тэтгэврийн даатгал	22,082,173.08	50,549,843.27
210202	Тэтгэмжийн даатгал	2,291,529.93	7,447,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,107,284.48	3,724,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	444,451.30	3,724,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,444,523.75	14,895,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,708,500.00	31,607,465.75
210301	Гэрэл, цахилгаан	2,837,900.00	3,111,795.75
210302	Түлш, халаалт	20,870,600.00	28,495,670.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,862,320.00	21,190,788.50
210401	Бичиг хэрэг	933,250.00	584,600.00
210402	Тээвэр, шатахуун	11,617,070.00	15,490,920.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	955,000.00	687,368.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	944,900.00	1,055,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,412,100.00	3,372,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,947,381.30	63,879,627.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,662,111.30	58,022,107.90
210502	Хоол, хүнс	3,785,270.00	3,547,520.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,500,000.00	2,310,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,622,100.00	18,290,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	360,000.00	-
210604	Урсгал засвар	14,262,100.00	18,290,100.00

2107	Томилолт, зочны зардал	1,782,000.00	12,190,000.00
210702	Дотоод албан томилолт	1,782,000.00	12,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,564,804.00	2,482,853.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	450,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	110,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,044.00	98,034.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	360,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	78,260.00	67,969.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	425,500.00	541,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,739,850.00	4,172,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,739,850.00	4,172,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200.00	98,134.25
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	200.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	200.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	98,134.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	98,134.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(10,591,330.86)	31,815,037.36
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,045,400.00	20,666,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,045,400.00	20,666,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,045,400.00	20,666,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,045,400.00	20,666,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,045,400.00)	(20,666,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(15,636,730.86)	11,148,337.36
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,829,183.58	2,192,452.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,192,452.72	13,340,790.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,735,018.94	254,074,632.82	427,809,651.76
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,735,018.94	254,074,632.82	427,809,651.76
5	Тайлант үеийн үр дүн	0.00	-32,161,470.21	-32,161,470.21
6	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,735,018.94	221,913,162.61	395,648,181.55
7	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	173,735,018.94	221,913,162.61	395,648,181.55
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	254,904.56	0.00
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	173,735,018.94	221,913,162.61	395,648,181.55
11	Тайлант үеийн үр дүн	0.00	217,754,503.13	217,754,503.13
12	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	173,735,018.94	439,412,761.18	613,147,780.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	657,699,900.00	646,613,554.02	11,086,345.98	98.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	657,699,900.00	646,613,554.02	11,086,345.98	98.3
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	657,699,900.00	646,613,554.02	11,086,345.98	98.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	400,765,500.00	393,742,175.60	7,023,324.40	98.2
210101	Үндсэн цалин	221,083,800.00	178,767,468.00	42,316,332.00	80.9
210102	Нэмэгдэл	132,303,700.00	155,757,808.00	(23,454,108.00)	117.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,590,000.00	7,358,000.00	6,232,000.00	54.1
210104	Урамшуулал	33,788,000.00	51,858,899.60	(18,070,899.60)	153.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	80,780,000.00	80,340,943.27	439,056.73	99.5
210201	Тэтгэврийн даатгал	50,988,900.00	50,549,843.27	439,056.73	99.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,447,500.00	7,447,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,724,100.00	3,724,100.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,724,100.00	3,724,100.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,895,400.00	14,895,400.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,705,600.00	31,607,465.75	98,134.25	99.7
210301	Гэрэл, цахилгаан	3,209,900.00	3,111,795.75	98,104.25	96.9
210302	Түлш, халаалт	28,495,700.00	28,495,670.00	30.00	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,894,900.00	21,190,788.50	704,111.50	96.8
210401	Бичиг хэрэг	625,700.00	584,600.00	41,100.00	93.4
210402	Тээвэр, шатахуун	15,819,700.00	15,490,920.50	328,779.50	97.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,079,200.00	687,368.00	391,832.00	63.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,034,000.00	1,055,400.00	(21,400.00)	102.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,336,300.00	3,372,500.00	(36,200.00)	101.1
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	64,319,900.00	63,879,627.90	440,272.10	99.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	57,251,900.00	58,022,107.90	(770,207.90)	101.3
210502	Хоол, хүнс	3,318,000.00	3,547,520.00	(229,520.00)	106.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,750,000.00	2,310,000.00	1,440,000.00	61.6
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38,956,800.00	38,956,800.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,666,700.00	20,666,700.00	(1,000,000.00)	105.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	-	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	18,290,100.00	18,290,100.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	12,500,000.00	12,190,000.00	310,000.00	97.5
210702	Дотоод албан томилолт	12,500,000.00	12,190,000.00	310,000.00	97.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,151,900.00	2,482,853.00	1,669,047.00	59.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	450,000.00	50,000.00	90.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	500,000.00	110,850.00	389,150.00	22.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	98,034.00	1,966.00	98.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	55,000.00	11,000.00	83.3

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,300,000.00	440,000.00	860,000.00	33.8
210807	Газрын төлбөр	100,000.00	67,969.00	32,031.00	68.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	865,900.00	541,000.00	324,900.00	62.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,625,300.00</b>	<b>2,222,900.00</b>	<b>402,400.00</b>	<b>84.7</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,625,300.00	2,222,900.00	402,400.00	84.7
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>657,699,900.00</b>	<b>659,711,891.38</b>	<b>(2,011,991.38)</b>	<b>100.3</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>36,495,700.00</b>	<b>36,397,565.75</b>	<b>98,134.25</b>	<b>99.7</b>
132001	Орон нутгийн төсвөөс	36,495,700.00	36,397,565.75	98,134.25	99.7
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>617,954,300.00</b>	<b>618,417,287.62</b>	<b>(462,987.62)</b>	<b>100.1</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	617,954,300.00	618,417,287.62	(462,987.62)	100.1
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>3,249,900.00</b>	<b>4,897,038.01</b>	<b>(1,647,138.01)</b>	<b>150.7</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	3,219,700.00	4,897,038.01	(1,677,338.01)	152.1
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	30,200.00			-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>30,259.74</b>		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>13,128,597.10</b>		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>21.00</b>	<b>13.00</b>	<b>-</b>	
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	8.00	-	
620003	Үйлчлэх ажилтан	6.00	4.00	-	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,501.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 9,489.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 328.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 6,684.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүллээ.

#### Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд ажиллагсадтай холбоотой авлага 9,489.3 мянган төгрөгийг дутуу тайлагнасан.

#### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 7,012.4 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 328.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 6,684.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага тус тус хүргүүлээ.

#### 3.1 Төлбөрийн акт

1.Жирэмсэн,амаржсаны чөлөөтэй ажилтнуудын НДШ-ийн хугацаа хоцролттой холбоотой алданги төлбөр 272,420.34 төгрөгийг цалингийн зардлаас төлсөн байна. Энэ нь [Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Нийгмийн](#)

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Ажил олгогч даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр тооцон суутгаж, ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос тооцсон шимтгэлийн хамт тухайн сард багтаан нийгмийн даатгалын санд төлнө/, 32 дугаар зүйлийн 32.2.2-т /орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/ гэж заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.Томилолтын нөхөн олговрыг илүү тооцон 56,000.00 төгрөгийг олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.2 / батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 2.2.Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ:/2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал / Сангийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар баталсан / 1.Төрийн албан хаагчийн албан томилолтын хоолны зардлыг суманд 30,000 төгрөг, аймгийн төвд 40,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 50,000 төгрөгөөр, байрны зардлыг суманд 60,000 төгрөг, аймгийн төвд 130,000 төгрөг, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад 150,000 төгрөгөөр тус тус шинэчлэн баталсугай /гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.2 Албан шаардлага

Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 100 хувиар тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.1. /Ажилтан үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн ажил олгогчдоо мэдэгдэх үүрэгтэй. /, 57.3.3-т /Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина. /, 84.4.-т /Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна/ гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн авлагыг дутуу тайлагнасан.	1	9,489.3					1	9,489.3				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>9,489.3</b>					<b>1</b>	<b>9,489.3</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Жирэмсэн, амаржсаны чөлөөтэй ажилтнуудын НДШ-ийн хугацаа хоцролттой холбоотой алданги төлбөрийг цалингийн зардлаас төлсөн.	1	272.4	1	272.4							
Томилолтын нөхөн олговрыг илүү тооцон олгосон	1	56.0	1	56.0							
Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 100 хувиар тооцож олгосон.	1	6,684.0			1	6,684.0					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>3</b>	<b>7,012.4</b>	<b>2</b>	<b>328.4</b>	<b>1</b>	<b>6,684.0</b>				<b>-</b>	<b>-</b>

#### 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			

2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			